

Хөгжингүй ба хожуу хүрлийн үеийн амьтны загварт урлагийн гол дүрүүд

Жамъян-Омбын Гантулга^{1,*}

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монголын хүрлийн үеийн хөгжлийн үе шат ба он цаг, хөрш бүс нутгийн хөгжингүй ба хожуу хүрлийн үеийн археологийн соёлуудын тухай, мөн амьтны загварт урлагийн эхэн үеийн зарим гол дүрүүд, тэдгээрийн бэлгэдэл зэргийг тодруулахыг зорьсон. Нүүдэлчдийн аж төрөх ёс, амьдралаас урган гарсан урлагийг “Амьтны загварт” хэмээн тодорхойлж ирсэн бөгөөд тэд “амьтны загварт урлаг”-ийн дүрүүдээ хоёр хэмжээст дүрслэлээс гурван хэмжээст дүрслэлд шилжүүлсэн нь дэлхийн урлагийн түүхэнд нүүдэлчдийн оруулсан үнэлж баршгүй гавьяа юм. Хөгжингүй ба хожуу хүрлийн үеийн урлагийн гол дүрүүд хожмын Аржан, Пазырык, Чандмань-Сагил, Дөрвөлжин булш, Тагарын соёлын урлагийн үндсэн дүрүүд болсон төдийгүй илэрхийлэх утга агуулгын хувьд гүн гүнзгий болж улам цааш төгс төгөлдөр болон хөгжсөн байна. Өөрөөр хэлбэл, нүүдэлчдийн бүтээсэн энэхүү “Амьтны загварт урлаг” анх НТӨ XIII зуунд Төв Азид, тэр дундаа одоогийн Монголын нутаг дэвсгэрт үүсэн хөгжиж, НТӨ VII-III зуун гэхэд нийт Евразийн өргөн уудам тал нутагт түгэн дэлгэрч, урлагийн оргил үедээ хүрсэн байна.

Түлхүүр үг: Амьтны загварт урлаг, гол дүрүүд, хөгжингүй хүрлийн үе, хожуу хүрлийн үе, археологийн соёлууд, Сибир, Умард Хятад, Монгол

Удиртгал

НТӨ II мянганы Төв Азийн түүх нь юуны өмнө нүүдэлчин овог, аймгуудын түүх бөгөөд тэрхүү эртний нүүдэлчдийн аж төрөх ёс, аж ахуй, өвөрмөц соёл болон угсаатны хувьд Хятадын суурьшмал соёл иргэншлээс эрс ялгардаг юм.

Нүүдэлчдийн аж төрөх ёс, амьдралаас урган гарсан урлагийг “Амьтны загварт” хэмээн тодорхойлж ирсэн бөгөөд энэхүү урлаг хөгжингүй хүрлийн үеэс буюу НТӨ II мянганы дунд үеэс эхлэн Евразийн өргөн уудам тал нутагт тархажээ. Амьтны загварт урлагийн гол онцлог нь дүрсэлж буй амьтныхаа гол шинжийг ялган тодруулж харуулах ба тухайн шинжид гол анхаарлаа төвлөрүүлж дүрсэлдэгт оршино. Дүрслэл зүй ба утга агуулгын энэ онцлогийг судлаачид олон удаа хөндөн бичсэн байдаг (Кубарев 1991: 138). Хамгийн эрт үед холбогдох амьтны загварт олдворууд Евразийн зүүн бүс нутгаас илүүтэй олддог ба Монголын Хиргисүүр-Буган хөшөөний соёл (НТӨ 1200-600), Сейма-Турбины соёл (НТӨ XVI - XIV зуун), Карасукын соёл (НТӨ 1300-800), Аржаны соёл (НТӨ IX-VIII зуун), Умард Хятадын хожуу Шангийн соёл (НТӨ 1200-1046), Баруун Жоугийн соёл (НТӨ 1045-771) зэрэг нь амьтны загварт урлагийн эрт үеийн төлөөллүүд хэмээн үзэж болно (Хүснэгт 1).

Нүүдэлчдийн амьтны загварт урлагийн оргил үеийг НТӨ VII-III зуунд тохиосон хэмээн үздэг ба энэ үед Хар тэнгисээс Хянганы нуруу хүртэлх Евразийн өргөн уудам тал нутагт түгэн дэлгэрч байжээ.

Бид энэ удаа амьтны загварт урлагийн эхэн үеийн зарим гол дүрүүдийн тухай авч үзэх бөгөөд энэ нь он цагийн хувьд хөгжингүй ба хожуу хүрлийн үед холбогдоно.

Энэ үеийн хадны зураг, буган хөшөө, эд зүйлс дээр амьтны дүр, дүрслэлүүд илүү бодитой олон удаа тохиолдохоос гадна амьтдыг дөнгөж загварчилсан байдалтай урлаж эхэлснээрээ онцлог юм.

Бүс нутгийн археологийн соёлууд

Хөгжингүй болон хожуу хүрлийн үеийн урлагийн зарим гол дүрүүдийн тухай өгүүлэхийн өмнө Монголын умард болон өмнөд бүс нутагт оршиж байсан археологийн зарим соёлуудын талаар товч дурдах нь зүйтэй болов уу.

Тухайн үед Монголын тал нутагт Мөнххайрхан, Сагсай хэлбэрийн булш, түрүүлгэ нь харуулсан оршуулгат булш, Хиргисүүр-Буган хөшөө, дөрвөлжин булшны соёл оршиж байсан бол Монголын умард хэсэгт Сейма-Турбины соёл, Минусын хотгороор Карасукын соёл, өмнөд хэсэгт хожуу Шиба, Ордос хавиар хожуу Чжукайгоу, Лицзя'яа, түүний зүүн урдуур хожуу Шан, баруун Жоугийн соёл оршин тогтнож байв (Зураг 1, 2).

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим

* Холбоо барих зохиогч: gantulga.j@num.edu.mn
<https://orcid.org/0000-0001-6482-5579>

Бүс нутгийн хэмжээнд тархсан ийм олон соёлуудын дунд тал нутгийн нүүдэлчдийн өвөрмөц соёл бие даан оршин тогтнож, өөрийн өнгө төрхөөрөө тэднээс ялгарч байсан нь гайхалтай. Монголын тал нутагт оршин тогтнож байсан дээрх соёлуудаас хамгийн өргөн уудам газар нутгийг хамарсан нэг соёлын нийтлэгийг бий болгож чадсан нь Хиргисүүр-Буган хөшөө болон Дөрвөлжин булшны соёлынхон юм.

Хөгжингүй хүрлийн үеэс түрүү төмрийн үе хүртэлх хугацаанд оршин тогтнож байсан дээрх олон соёлууд ээлж дараалан, зарим үед зэрэгцэн оршин тогтнож байсныг сүүлийн үеийн археологийн судалгаануудын ололт амжилтаас харж болно. Мөн Монголд сүүлийн 20 орчим жилийн хугацаанд эрчимтэй хийсэн археологийн судалгаанд үсрэнгүй ахиц гарч Монголын хүрлийн үеийн соёлуудын ерөнхий дүр зургийг харах боломжтой болсон юм. Өөрөөр хэлбэл, Монголын хүрлийн үе дараах гурван үеийг дамжин хөгжжээ. Энэ нь:

- Түрүү хүрлийн үе (НТӨ 2600 - 2100)
- Хөгжингүй хүрлийн үе (НТӨ 2000 - 1600)
- Хожуу хүрлийн үе (НТӨ 1500 - 800) болно

(Хүснэгт 2; Зураг 1, 2).

Үүнээс гадна дээрх соёлынхоны оршин тогтнож байсан газар нутаг, тархалт, оршуулгын зан үйл зэрэг олон зүйлийг тодорхойлж, тогтоогоод байгаа билээ. Тухайлбал, Хөгжингүй хүрлийн үеийн Мөнххайрханы соёлын дурсгал өнөөгийн байдлаар манай улсын Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Булган аймгуудын нутгийг хамарч байгаа бол Сагсай хэлбэрийн булшны соёлыг үлдээгч нар хойшоо Хөвсгөл нуурын өмнөд хэсэг, зүүн тийш Хангайн нурууны зүүн бие, баруун урагш Говийн Алтайн өвөр, баруун тийш Монгол Алтайн нурууны зүүн бие, урагш Говийн Алтайн нурууны төгсгөл хэсэг хүртэлх газар нутгийг эзэмшиж байжээ. Харин түрүүлгэ нь харуулсан оршуулгат булшны соёлынхон Дорнод Монголын тал нутгаас Өмнөд Монгол, Төв Монголын урд хэсэг, Баруун Монголын зүүн урд хэсэг хүртэлх нутагт оршин сууж байв.

Харин хожуу хүрлийн үеийн хиргисүүр Монгол улсын төв, баруун хэсэг буюу Хэнтий аймгийн баруун хэсэг, Сүхбаатар аймгийн хойд хэсгээс баруунш нийт нутгийг хамрах төдийгүй хил залгаа ОХУ-ын бүрэлдэхүүнд багтах Буриад улс, Тува улс, Алтай улсын нутаг дэвсгэрт тархсан байна. Мөн БНХАУ-ын Шинжаан-Уйгурын өөртөө засах орны хойд хэсгээр түгээмэл тархажээ.

Тэгвэл Дөрвөлжин булшны соёлынхоны зүүн хязгаар нь Далай нуур, Халх гол, Хянганы нурууны баруун бэл хүрдэг. Өмнөд хязгаар нь төдий л тодорхой бус бөгөөд Нань-Шань уулын хойд биеэс Инь-Шань уулын хойд бэл хүртэл, Монгол улсын хилийн шугам дагуу үргэлжилнэ. Баруун хязгаар нь Их нууруудын

хотгор, Говийн Алтайн баруун биеэр, хойд хязгаар нь Хөвсгөл нуурын хойд зах, Зэд голын хөндий, Хамар давааны урд бэл, Улаан-Үд хотын хойгуур Сэлэнгэ мөрний хөндийг оруулан Шилка гол хүрнэ (Төрбат, Эрдэнэболд 2020: 93).

Мөн эдгээрээс гадна Монгол Алтайн Сагсай хэлбэрийн булшны оршин суугчид генийн хувьд өрнөдийн болон дорнодын хэв шинж холимог бүтэцтэй байсныг тодорхойлсон ба зарим бодгаль хөх нүдтэй, цайвар үстэй байсныг тогтоожээ. Баян-Өлгийн Цагаан Асга ба Цагаан голын хоорондоо алслагдсан дурсгалуудаас илэрсэн хоёр бодгал генийн хувьд холбоотой байгааг тогтоосон нь хүрлийн үеийн нийгмийн ба овгийн байгууллын талаар чухал баримт болох юм. Үүнээс дутахгүй чухал нэгэн дүгнэлт бол нэгэн оршуулгын газрын дотор байх удам төрлийн холбоог илрүүлсэнд оршино (Hollard *et al.* 2014).

Өмнөд Сибирийн хөгжингүй ба хожуу хүрлийн үеийн соёлуудаас Сейма-Турбин болон Карасукийн соёлын зарим эд өлгийн зүйлсээс “амьтны загварт урлаг”-ийн эхэн үеийн зарим дүрүүдийг харж болно.

Сейма-Турбины соёлын үзэгдэл Монгол Алтайгаас баруун хойшоо Финланд, Эстоны өмнөд хэсэг хүртэлх өргөн уудам газар нутагт тархсан гэж үздэг. Энэхүү соёлыг тодорхойлогч гол зүйл бол намхан бахим биетэй, бүдүүн хүзүү, том толгойтой адууны дүрс бүхий толгтой богино хүрэл илд, хутга, янз бүрийн хээ чимэглэл бүхий ооль, жадны гилбэр зэрэг юм. Адууг ихэвчлэн бүтэн биеэр нь богино илд, хутганы толт дээр урлахаас гадна зөвхөн толгойг нь гаргаж урласан хүрэл хутгууд бий (Зураг 14. 1-4). Ер нь Сейма-Турбины соёлынхон болон тал нутгийн нүүдэлчдийн хоорондох харилцаа холбоо нэг их тод ялгарч харагддаггүй.

Харин Минусын хотгорын Карасукийн соёл оршин тогтнох цаг хугацааны турш өмнөд хөрш (Хиргисүүр-Буган хөшөөний соёлынхон) болон умард хөршийн хооронд соёлын холбоо харилцаа байсан нь харагддаг. Карасукийн соёл нь хөгжлийн хэд хэдэн үе шатыг дамжин хөгжсөн ба уг соёлыг тодорхойлогч гол элемент болох мөөгөн хэлбэрийн болон амьтны толгойн дүрс бүхий балтагтай хүрэл хутга, гурван соёотой цагариган бариултай хутга, олон янзын хээ чимэглэл бүхий шавар сав суулга зэрэг юм. Харамсалтай нь Карасукийн соёлын оршуулгаас хүрэл эд өлгийн зүйлс тун цөөн тоотой гардаг ба харин түүвэр байдлаар Монгол, Өвөр Монгол, Умард Хятадаас нэлээд олддог юм.

Карасукийн соёлын үүсэл гарлын асуудлаар онолын цөөнгүй үзэл баримтлал байдаг бөгөөд тэдгээрээс Э.А.Новгородагийн онолыг илүү сайн үндэслэл дээр тулгуурласан гэж судлаачид онцлон тэмдэглэдэг. Тус онолоор карасукийн хүрэл эдлэлийн үйлдвэрлэлийн төв нь Умард Монголд байсан ба карасукчууд

энэхүү анхдагч төвөөс Минусын хотгорт шилжин суурьшиж, хожуу андроновчуудтай холилдон бол нөгөө хэсэг нь Минусын хотгорын өмнөд этгээдэд Окуневын соёлын зарим элементийг зээлдэн авсан ажээ. Умард Монголын хаа нэгтэйгээс хөдөлсөн нүүдэлчдийн гурав дахь бүлэг нь зүүн зүгт Хятадын баруун болон умардад очиж сууснаар карасукийн хэв шинжийн олон хүрэл эдлэл бий болоход хүргэсэн юм (1989: 125-129) гэдэг. Өөрөөр хэлбэл, Умард Хятадад карасукийн хүрэл эдлэл түгэн дэлгэрэхэд нүүдэлч олон овог, аймгууд буюу Хиргисүүр-Буган хөшөөний соёлынхон болон тал хээр, говийн бүсийн түрүүлэг нь харуулж оршуулдаг өвөрмөц зан заншилтай соёлынхны харилцаа холбоо чухал үүрэгтэй байжээ. Гэхдээ Хиргисүүр-Буган хөшөөний соёлыг тээгчид бол карасукууд биш харин карасукийн хэв шинжийн соёлыг тээгч гол ард түмэн гэж үзэж болох бөгөөд буган хөшөө бол үүний тод жишээ юм.

Түүнчлэн судлаачид карасукуудыг антропологийн хэв шинжээр монгол болон памир-ферганы европ төрхтний завсарын хэв шинжтэйгээс гадна зарим нэг шинж тэмдгээрээ өмнөх үеийн андронов ба окуневын тодорхой бүлгүүдтэй төстэй гэж үздэг (Новгородова 1989: 125-129). Тухайлбал, Карасукийн соёлын хойт хэсэгт андроновын төрх, өмнөд хэсэгт окуневын төрх илэрдэг нь андроновчууд Минусын хотгорын умард этгээдийг эзлэх явцад окуневчууд өмнө зүгт шахагдан шилжсэн түүх, соёлын үйл явцын чиг хандлагатай таардаг байна.

Мөн Хятадын Инь (Шан) улсын иргэншлийн төвтэй нүүдэлчдийн овог, аймгийн хүчирхэг нэгдэл зэрэгцэн оршиж байсан нь эртний хятадын соёлын хөгжилд зохих ёсоор нөлөө үзүүлсэн юм. Сүүлийн тавь гаруй жил явуулж байгаа археологийн судалгаа нь Хятад болон Умардын нүүдэлчдийн харилцаа холбооны олон талыг нээн илрүүлэхэд чухал алхам болж байгаа ба Хятадын эртний соёлд мэдэгдэхүйц нөлөөлснийг тогтоогоод байгаа юм. 1950-иад оны дунд үед хэвлэгдсэн Макс Лоерийн бүтээлүүдэд хятадуудын умардын “бүдүүлэгүүд” хэмээн нэрлэдэг овог, аймгууд Инь улсын хүрлийн үйлдвэрлэлд голлох нөлөө үзүүлснийг Аньяны археологийн цогцолбороос гарсан карасукийн хэв шинжийн гэж тодорхойлдог эд өлгийн зүйлс дээр тулгуурлан баримттайгаар нотолсон юм (Loehr 1953: 42-53; 1956).

Монголын буган хөшөөнд Карасук, Инь, Аржан, Пазырык, Тагарын соёлуудыг тодорхойлогч эд зүйлс, хээ чимэглэл, ан амьтан, зэр зэвсэг гээд олон зүйл дүрсэлсэн байдаг (Зураг 3, 4, 5).

Хиргисүүрийн оршуулганд эд өлгийн гэхээр зүйлс дагалдуулдаггүйг судлаачид тэдгээрийн зан үйлийн онцлогтой холбон тайлбарладаг бөгөөд Хиргисүүр-Буган хөшөөний соёлынхон тэдгээр эд өлгийн зүйлсийг үйлдвэрлэж байгаагүй гэсэн үг огт биш юм.

Тухайн үеийн карасукууд болон Хятадын Инь (Шан), Баруун Жоу улсуудтай харилцаж байсан Төв Азийн хүчирхэг ард түмэн бол яахын аргагүй Хиргисүүр-Буган хөшөө, Шоргоолжин булшны (*түрүүлэг нь харуулсан оршуулгат булш*) соёлынхон мөн билээ.

Урлагийн гол дүрүүд, тэдгээрийн бэлгэдэл

Нүүдэлчдийн аж төрөх ёс, бодит амьдралаас урган гарч, бүтээлч сэтгэлгээгээр баяжин хөгжсөн хадны зураг, буган хөшөө, чимэглэх урлагийн дурсгалууд нь эртний орон зайн урлагийн дурсгалууд гарцаагүй мөн юм (Цэвээндорж 1999).

Эдгээр дурсгалуудаас хөгжингүй ба хожуу хүрлийн үеийн урлагийн гол дүрүүдийг тодорхой харж болно. Энэ үеийн урлагийн гол дүрүүдэд ерөнхийдөө зэрлэг ан амьтад (өвсөн тэжээлт болон махан идэшт) зонхилдог. Өвсөн тэжээлт амьтад янгир, аргаль, адуу, буга, гахай, шувуу, туулай зэрэг амьтад, махан идэшт амьтад ихэвчлэн мийгийн овгийн амьтад, чоно, нохой зэрэг байна. Эдгээр гол дүрүүдийн амьтдыг шүтлэг бишрэлийн холбогдолтой зүйлс, гоёл чимэглэл, дээл хувцас, бүсний чимэглэл, адуу малын тоног хэрэгсэл, тэрэгний эд анги, толь, сав суулга болон зэр зэвсэг зэрэг дээр хоёр болон гурван хэмжээст байдлаар урласан байдаг (Хүснэгт 1).

Тиймээс эдгээр гол дүрүүдийг:

- Хадны зургийн гол дүрүүд
- Буган хөшөөний гол дүрүүд
- Эд өлгийн зүйлс дээрх гол дүрүүд хэмээн урласан байдлаар нь гурав хуваан үзэж болох юм.

Хадны зургийн гол дүрүүд. Хадны зураг нь эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, шашин шүтлэг, нийгэм, эдийн засаг, соёлыг судлахад чухал сурвалж хэрэглэгдэхүүн болдог. Монгол орон хадны зургийн дурсгалаар нэн баялаг орны тоонд зүй ёсоор ордог. Одоогоор хүрлийн үед холбогдох хадны зургийн дурсгалт газар 500 гаруй илэрч олдоод байгаа бөгөөд тэдгээрийн ихэнх нь хожуу хүрлээс түрүү төмрийн үед холбогдоно. Энэ үеийг монголын хадны зураг урлалын оргил үе гэж хэлж болно. Энэ үеийн хадны зургийг улаан зосоор эсвэл хадыг хонхойлон сийлж урласан байдаг ба тэдгээрт зэрлэг ан амьтдын сэдэвт зураг голлож, дараа нь аж байдлын сэдэвт зургууд орно (Зураг 6. а, б). Зэрлэг ан амьтад дотор хамгийн олон тоогоор дүрслэгдсэн амьтан бол янгир, түүний дараа буга, араатан амьтад (чоно, үнэг гэх мэт), гахай, адуу, үхэр зэрэг амьтад орно. Тэдгээр амьтдыг ихэвчлэн сүргээрээ буюу ганц нэгээрээ бэлчиж яваа, тайван зогсож байгаа, эсвэл давхиж яваа зэргээр дүрсэлсэн байдаг. Эртний хүмүүсийн амьдрал, оюун санааны хөгжилд амьтад ямар үүрэг гүйцэтгэж байсныг хадны зургаас тодорхой харж болдог. Тухайлбал, янгир хоол тэжээлийг хангагч гол эх үүсвэр нь болж байсан

бол адуу эртний нүүдэлчдэд чухал үүрэгтэй байсан (уналга, ачилганд ашиглах, тэргэнд хөллөх гэх мэт), гаршуулж гэршүүлсэн амьтад хүний амьдрал ахуйд онцгой ач холбогдолтой болж ирсэн, буга, хандгай, чоно, баавгай зэрэг амьтад тухайн овог аймгийн тотем бэлгэдэл байсны зэрэгцээ бөө нарын онгод, тэнгэрийн унаа хэмээн үздэг байсан, араатан амьтдын хувьд хүний амьдралд ямар нэгэн байдлаар учруулдаг хор хохирлоос хамгаалах гэсэн санааг илэрхийлж байсан бололтой. Мөн хадны зурагт амьтдын зохиомол (домгийн) дүр цөөнгүй тохиолдож байгаа нь эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, зан заншилтай холбоотойгоор тайлбарлагдана. Хадны зургийн гол дүр бүрийг нэг бүрчлэн авч үзэх боломжгүй тул энд зөвхөн янгир, адуу, буга зэрэг амьтдыг төлөөлөл болгон оруулав.

Буган хөшөөний гол дүрүүд. Хадны зурагт түгээмэл дүрслэгдсэн амьтад буган хөшөөнд мөн дүрслэгдсэн байдаг. Буган хөшөөний гол дүрүүд нь ан амьтад бөгөөд хамгийн олон тоотой дүрслэгдсэн амьтад бол туурайтан амьтад (буга, согоо, хандгай, адуу, янгир, гахай, үхэр), дараа нь араатан амьтад юм. Тэдгээр амьтдыг төрөл зүйлээр нь туурайтан амьтад, араатан амьтад, жигүүртэн, загас ба мэлхий хэмээн ангилж болно.

Монголоос олдсон нийт 1241 буган хөшөөнөөс 794 хөшөөнд буюу 64 % -д ан амьтад сийлжээ. Тэдгээр амьтдаас хамгийн олон хөшөөнд дүрслэгдсэн нь буга, адуу, янгир, мийгийн овгийн амьтад, гахай зэрэг болно (Зураг 5). Эдгээр хөшөөдийн тархалтыг харахад ихэвчлэн Хангайн нурууны эргэн тойрон, Хөвсгөлийн уулс, Монгол Алтайн нуруу даган тархсан байна. Харин Саян-Алтайн төрлийн хөшөөнд хамгийн олон төрлийн амьтад буюу буга, адуу, янгир, гахай, хандгай, чоно, нохой, араатан, шувуу зэрэг амьтад сийлсэн байдаг. Эдгээр олон төрлийн амьтдаас голлох хэдэн дүрийн амьтдыг төлөөлөл болгон оруулав.

Эд өлгийн зүйлс дээрх гол дүрүүд. Тал нутгийн нүүдэлчид чулуу, яс зэрэг энгийн материалаас эхлэн алт зэрэг үнэт, өнгөт төмөрлөг дээр урлагийн дахин давтагдашгүй бүтээлүүд туурвиж ирсэн бөгөөд тэдгээрээс хүрлийг гарамгай эзэмшин боловсруулж, түлхүү хэрэглэж байсан байна. Нүүдэлчид алтаар жижиг хэмжээтэй гоёл чимэглэлийн зүйлс, хашаар хувцас хэрэглэлийн унжлага зэрэг гоёл чимэглэл болон зан үйлийн зориулалттай зүйлсийг хийж байсан бол хүрлээр бүх төрлийн зүйлсийг янз бүрийн хэлбэр, төрх, хэмжээтэйгээр урлан бүтээж байжээ (Хүснэгт 1).

Хүн. Хүний дүр энэ үеийн эд өлгийн зүйлс дээр харьцангуй цөөн тохиолдох бөгөөд хүнийг шүтлэг бишрэлийн холбогдолтой зүйлс, бүсний чимэглэл болон зэр зэвсэг дээр урлажээ. Ингэхдээ хүнийг хоёр янзаар буюу зөвхөн нүүрийг эсвэл бүтэн биеэр нь

дүрслэн үзүүлжээ. Шүтлэг бишрэлийн холбогдолтой гэж үзэж болох хүний нүүрний дүрст болон хүн дүрст хүрэл онгууд (?) Монгол болон Умард Хятадаас хэд хэд олджээ (Хүснэгт 1, Зураг 7. 1-8). Харин эд зүйлс болон зэр зэвсэг дээр урласан хүний дүр харьцангуй цөөн тоотой юм. Тухайлбал, хүний нүүрний дүрс бүхий толттой хүрэл хутга (Зураг 15. 14), нум сум агссан хүн, морин тэрэг болон ан амьтад бүхий зохиомжтой ясан сийлбэр (Зураг 10. 7), морьтон болон адуу дүрсэлсэн бүсний хүрэл шахуурга (Хүснэгт 1), хүний дүрст хүрэл ооль болон саадагны хүрэл чимэглэл (Хүснэгт 1) зэрэг зүйлс Умард Хятадаас олдсон бол хоёр адуу, нэг хүний дүрс бүхий толттой хүрэл хутга Сибирийн Сейма-Турбины соёлын дурсгалаас тус тус олдсон байдаг (Зураг 14. 3). Харин Монголын тал нутгаар өргөн тархсан буган хөшөөдөд хүний нүүрний дүрс бүхий хөшөө 10 гаруй бий бол хэд хэдэн хүн дүрсэлсэн хөшөө Булганы Орхон, Архангайн Ихтамир сумдын нутгаас тус бүр нэг олджээ (Батсүх 2018: 352-399; Гантулга, Идэрхангай 2018: 40-207).

Янгир. Янгир нь бүр чулуун зэвсгийн үеэс хад чулуунаа дүрслэгдэж эхэлсэн бөгөөд улмаар хүрэл зэвсгийн үед урлагийн гол дүр болсон амьтан юм. Хүрлийн үеийн хүмүүсийн оюун санаа, ертөнцийг үзэх үзэл, сүсэг бишрэлд чухал байр суурь эзэлж байсныг хадны зурагт хэдэн арван мянгаараа урлагдсан янгирын дүрээс тодорхой харж болно. Хадны зурагт янгирыг илэрхийлэх гол шинж болох эврийг маш олон хэлбэрээр дүрслэн үзүүлсэн байдаг бөгөөд ерөнхийд нь их биеийн дагуу хойш хондлой сүүл шүргэсэн бахим бүдүүн, нуруу орчимд хүрсэн богино махирдуу, голоороо үл ялиг тахийсан үзүүр хэсгээрээ шовх эгц босоо, угалзруулан цагаригласан байдалтай дүрсэлдэг. Янгирын биеийг бүх талбайгаар нь хонхойлон цохих, эсвэл биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохих гэсэн хоёр аргаар урласан байх ба бүх талбайгаар нь хонхойлон цохисон янгирын зураг ихэнх хувийг эзлэнэ. Мөн түүнчлэн янгирыг бодитой дүрслэхээс гадна эх биеийг эрэн болгож дүрсэлсэн, дугуй биетэй, урт нарийн нугаларсан хүзүүтэй, хоёр тийш солбисон эвэртэй болон эврийн хоорондох зайг хонхойлон цохиж малгай мэт болгосон зэрэг нэлээд өвөрмөц байдлаар дүрсэлсэн янгирын зургууд ч бас тохиолддог. Хадны зурагт янгирын дүр тооны хувьд давамгайлж байгааг зурж дүрслэхэд хялбар байдгаас гадна ан агнуурын болон шүтлэг бишрэл, бөө мөргөлийн элдэв зан үйлд чухал үүрэгтэй байсан хэмээн үздэг төдийгүй тэр үеийн хүмүүсийн орчинд бусад амьтдаас илүү тархмал байж, үндсэн ан нь болж байсан тул хүмүүс түүний арьс ширээр нь хувцас хунар хийх, махыг нь хүнс тэжээл болгон хэрэглэдэг байжээ. Гэхдээ хад чулуунд дүрслэгдсэн янгирын зураг эртний хүмүүсийн өвөг дээдэс буюу тотем нь гэдгийг батлахад хэцүү бөгөөд харин хурдан амьтан

гэдэг талаасаа ямар нэгэн байдлаар зүгээр нэг бэлэг тэмдэг (символ) байсан байх магадлалтай. Учир нь тотем-д ихэнхдээ ямар нэгэн сүр хүчтэй, хүчирхэг амьтад (шувуу, чоно, буга гэх мэт) сонгогддог байсан.

Тэгвэл Монголын 1200 гаруй буган хөшөөд дотор янгир дүрсэлсэн 32 хөшөө байна. Тэдгээр янгирогийг ихэвчлэн загварчилсан буга дүрсэлсэн хөшөөнд дүрсэлжээ. Ингэж дүрслэхдээ бугуудын хоорондох завсар зайд жижиг хэмжээтэй, эх биеийг бүх талбайгаар нь хонхойлон цохих аргыг түлхүү ашигласан байхын зэрэгцээ цөөн хэдэн янгирын эх биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохиж урласан байна. Биеийн ерөнхий төрх нь бодит байдалтайгаа дөхүү байхаас гадна адуу мэт биетэй, дүрлэгэр дугуй нүдтэй, босоо соотон чихтэй, богинохон босоо сүүлтэй, заримдаа бүр сүүл, чихийг огт дүрслээгүй зэрэг харилцан адилгүй төрх байдалтай дүрсэлсэн нь ч тохиолддог (Зураг 2).

Байгалийн хаданд анх дүрслэгдэж байсан янгирын дүр улмаар буган хөшөө хийгээд бусад эд өлгийн зүйлс дээр урлагдах болжээ. Тухайлбал, Монгол, Өмнөд Сибир, Умард Хятадаас янгирын толгойн дүрст толгтой хүрэл илд, чичлүүр хутга, хутга, шөвөг нэлээд олон тоогоор олддог (Хүснэгт 1, Зураг 13. 1-9, 13-15, 21, 29, 30, 7. 6, 8, 11, 14, 30, 31, 34, 13. 1-6, 10, 11). Эдгээрээс гадна үүрэг зориулалт нь тодорхойгүй янгирын (аргаль ?) дүрст эдлэл Монголоос 2, Умард Хятадаас нэг олдсон байна. Зарим судлаачид уг эдлэлийг хөгжмийн зэмсэгийн чавхдас татаж чангалах хэрэгсэл хэмээн тайлбарласан нь ч бий (Хүснэгт 1, Зураг 8. 7-9). Улмаар түрүү төмрийн үе болоход янгирогийг илүү олон төрлийн эд зүйлс дээр урлах болжээ.

Буга. Энэ үеийн хадны зурагт бугыг ерөнхийдөө бодит болон загварчилсан байдлаар дүрсэлсэн байдаг. Бодит байдлаар дүрсэлсэн бугын зургууд хөгжингүй хүрэл, загварчлан дүрсэлсэн бугын зургуудыг хожуу хүрлээс түрүү төмрийн үед холбогдуулан үздэг. Бугыг загварчлан дүрслэхдээ буган хөшөөнд дүрсэлдэгтэй тун адилхан олон салаа эврийг нь нурууг дагуулан дүрсэлж шувуу шиг урт нарийн хошуутай, толгойгоо дээш өргөж урд, хойд хөлөө нугалан тэнгэрт дүүлэн нисч буй мэт урласан нь уг хоёр дурсгалын он цагийг тогтооход харьцуулах хэрэглэгдэхүүн болдог. Энэ мэт хадны зурагт бугын дүрийг буган хөшөөнд дээрхтэй адил загварчлан дүрсэлсэн зураг цөөнгүй тохиолдог. Тухайлбал, Төв Монголын Хөрөөгийн үзүүр, Монгол Алтайн Цагаан Салаа, Бага Ойгор, Ямаан ус зэрэг газрын хадны зурагт буган хөшөөнийхтэй адил загварчилсан бугын дүр олонтоо тохиолдох ба судлаачид тэдгээрийг хожуу хүрэл, түрүү төмрийн үеийн дурсгалуудтай харьцуулан судалжээ (Гантулга, Ерөөл-Эрдэнэ, Магай 2018; Jacobson et al. 2001: 45, 225, 227).

Мөн угсаатны зүйн судалгааны хэрэглэгдэхүүнд бугын дүр нь нүүдэлчдийн шүтлэг бишрэл, бөө мөргөлтэй салшгүй холбоотойг илтгэх баримт цөөнгүй тохиолдоно. Дархадын бөөгийн ёсонд онгодоо дуудаж ирүүлэхэд хөлөг унаа нь болох бугын арьсаар хийсэн хэнгэрэг дээр улаан зосоор тухайн бугыг авлахын цагт ямар төрх байдалтай байсан тэрхүү байдлаар нь амьдчилж зурдаг ёс үлдэж хоцорчээ (Бадамхатан 1965: 210). Энэ нь тэр амьтны дүрс хувилж бөөгийн хэнгэрэгний бүрээс болж байгаа болохоос бус үхсэн гэж үздэггүй, харин нартын орноос харанхуйн оронд мөнхөрч онгод тэнгэрийн унаа болон хувирч байгаа хэмээн тайлбарладаг” (Пүрэв 2009: 254-255) зэргээс үзэхэд эрт үед бугыг онгод тэнгэрийн унаа болж хүний ертөнцөд ирдэг, хүнд гэм хоргүй амьтан хэмээн үзэж бодит байдлаар болон уран сайхны аргаар загварчлан зурдаг байсан бололтой. Ийнхүү буга нь эртний нүүдэлчдийн сэтгэлгээнд онцгой байр суурь эзэлж ариун нандин, эрхэм чухалд тооцогддог байсныг хадны зургаас харж болно.

Тэгвэл буган хөшөөнд бугыг бодит эсвэл загварчилсан байдлаар дүрсэлдэг ба загварчилсан бугын дүр бүхий хөшөө хамгийн олон тоотой олджээ. Мөн бугыг тэгш ба сондгой тоотой сийлсэн нь бий. Хамгийн олон буюу 68 буга дүрсэлсэн хөшөө Архангайн Өндөр-Улаан сумын Жаргалантын аманд (164-р хөшөө) бий. Загварчилсан бугын дүрст хөшөөдөд ихэнх тохиолдолд бугыг хөлөө нугалан тэнгэрт дүүлэн нисэж буй мэтээр дүрсэлсэн нь тухайн нас барсан хүний сүнсийг тэнгэрт гаргаж байна гэсэн бэлгэдлийг агуулж байна гэж үздэг. Буган хөшөөг нас барсан хүнд зориулсан дурсгал хэмээх тайлбарыг эш болгон төсөөлвөл хөшөөнөө дүрслэгдсэн буга нь сүнсний унаа бололтой. Хожмын хүннү нарын булш оршуулга, ялангуяа язгууртны булшнаас буга төдийгүй луу, бэлгэт гөрөөс, сарлаг мэт домог (тэнгэр)-ийн амьтны дүрслэл бүхий чимэглэл цөөнгүй олддог. Тэдгээр нь оршуулганд дагалдуулсан тэрэгний хударга, хөмөлдөрөгний чимэглэл болох ба тэнгэрт буйгаар дүрсэлсэн нь нас барсан язгууртныг эгэл хүнээс ангид, тэнгэр гаралтайн илэрхийлэл болохоос гадна түүний сүнсийг тэнгэрт гарахад хамгаалах бэлгэдэлтэй холбоотой байсан бололтой. Энэ нь буган хөшөөнөө бугыг шувуу мэт халин нисч буйгаар урладаг байсан шүтлэгийн уламжлал байж болох юм.

Буга нь тухайн цаг үеийн нүүдэлчдийн тотем амьтан болсон байсныг буган хөшөө хэмээх гайхамшигт сүрлэг сайхан дурсгал илтгэн харуулдаг. Ийнхүү бугыг хөшөө чулуунд загварчлан дүрслэхээс гадна эд зүйлс дээр цутгаж урлах нь мөн түгээмэл болж иржээ. Тухайлбал, Өмнөд Сибирээс олдсон цомцойн зогссон 6 бугын дүрст хүрэл толь, Монгол, Умард Хятад, Өмнөд Сибирээс олдсон хэдэн арван хүрэл хутга, бүсний тоног хэрэгсэл, хашаар хийсэн

бугын дүрст эдлэл зэргийг дурдаж болно (Хүснэгт 1).

Адуу. Адууг хаданд дүрслэхдээ биеийг бүх талбайгаар нь хонхойлон цохих, эсвэл биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохих гэсэн хоёр арга ашигласан байдаг. Хадны зураг дахь адууны дүрслэлээс харахад эртний нүүдэлчид одоогийн монгол адуу шиг намхан биетэй, тэсвэр хатуужил сайтай адууг өсгөн унаж эдэлдэг байсан нь тодорхой харагддаг. Харин цөөн тохиолдолд адууг урт хөлтэй, өндөр зэгзгэр биетэй, урт нарийн хүзүүтэй дүрсэлсэн нь нутгийн уугуул адуунаас арай өөр үүлдрийн адуу бололтой байдаг. Энэ нь адууг уналга, хөсөгт хэрэглэж эхэлснээр тухайн нутаг бүрийн түгжигдмэл явцуу байдлыг эвдэж хөрш зэргэлдээ ба алс холын овог аймаг, ард түмэнтэй харилцах худалдаа, эдийн засаг, соёлын харьцаа холбоо ихээхэн тэлснийг харуулах баримт юм. Адуугүйгээр нүүдэлчдийг төсөөлөхийн ч аргагүй бөгөөд адууны дүр бусад малыг (үхэр, тэмээ, хонь, ямаа) бодвол их дүрслэгдсэн байгаа нь тал нутгийн эртний нүүдэлчдийн мал сүргийн чухал салбар нь адуу байж нүүдлийн мал аж ахуй унааны морьгүйгээр хөгжих боломжгүй байсныг мөн харуулдаг.

Буган хөшөөнд бугын дараа хамгийн олон тоотой дүрслэгдсэн амьтан бол адуу юм. Адууг зогсож буй болон давхиж яваа байдалтайгаар хөшөөний дунд, доод хэсэгт биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохих болон бүх талбайгаар нь хонхойлон цохих аргаар дүрсэлсэн байдаг. Адууг ихэвчлэн загварчилсан бугатай хамт дүрсэлсэн байх бөгөөд бугаас жижиг хэмжээтэй дүрсэлсэн байдаг ч зарим нэг тохиолдолд том хэмжээтэй дүрсэлсэн нь ч таардаг (Зураг 3). Адуу бол нүүдэлчдийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээнд чухал үүрэг гүйцэтгэхийн сацуу нөгөө талаар тэдний оюун санаа, шүтлэгийн ухамсарт гүн ул мөрөө үлдээжээ. Тиймээс ч Төв Азийн ард түмнүүдийн үлгэр, туульс, бөө мөргөлийн үзэл санаанд адууны тухай арвин баялаг зүйлс уламжлагдан үлдсэн байдаг.

Тал нутгийн нүүдэлчдийн хувьд адуу хамгийн эрхэм амьтдын нэг байсныг олон зүйлээс тодорхой харагддаг. Тухайлбал, хэдэн мянган адууны зүлд бүхий тахилгын байгууламжуудтай аварга том хиргисүүрүүд, хэдэн зуун тахилгын байгууламжуудтай буган хөшөөний цогцолборууд байна. Үүнээс гадна адууны дүрст шүтлэг бишрэлийн холбогдолтой зүйлс, бүс, тэрэгний тоног чимэглэл, зэр зэвсэг хэдэн арваар олддогийг дурдаж болно (Хүснэгт 1, Зураг 10. 9-11, 8, 13. 16, 18-20, 26, 28, 14. 1-4, 20, 15. 8, 9, 23, 24). Мөн Хангайн нурууны өвөрт орших Өвөрхангайн Нарийнтээл сумын нутгаас Сейма-Турбины соёлыг илэрхийлэгч адууны дүрстэй ижил хэв маягаар урласан адууны дүрс бүхий хүрэл эдлэл (хутганы толт?) -ийн хэсэг олдсон нь тун сонирхолтой байна (Зураг 10. 1).

Аргаль. Аргаль мөн янгиргаас дутахгүй тухайн

үеийн урлагийн гол дүрийн амьтдын нэг болсоор иржээ. Аргалийг хэд хэдэн төрлийн эд зүйлс дээр буюу гоёл чимэглэл, бүсний тоног чимэглэл болон зэр зэвсэг дээр урласан байдаг. Тухайлбал, гоёл чимэглэлийн зүйлс гэвэл Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулын нэг шоргоолжин булшнаас уран нарийн хийцтэй хос алтан эдлэл илэрч олдсоныг дурдаж болно. Энэхүү эдлэлийн нэг талын төгсгөлд сартгар хамартай угалзарсан эвэртэй аргалийн толгой, түүний сээр нурууг 6 болон 8 оюу шигтгээ бүхий багана нуруу хээгээр чимэглэжээ (Бадма-Оюу 2018: 31). Үүнтэй төстэй алт, хүрлээр хийсэн эдлэлүүд баруун Монгол, өмнөд Сибир болон умард Хятадаас тус бүр нэг олдсон байна (Хүснэгт 1, Зураг 7). Харин аргалийн дүрийг хувцас хэрэглэл дээр зүүж тогтоох чимэглэл болон зэр зэвсгийн зүйлс дээр урласан нь олонтоо тохиолддог (Хүснэгт 1, 13. 10-12, 14. 5, 7, 12, 13, 15, 17-19, 23-25, 32, 15. 7, 12, 21, 22, 25).

Гахай. Монголоос гахай дүрсэлсэн буган хөшөө 12 олдсон бөгөөд тэдгээрийг буга, адуу, араатан, янгир, шувуу, мэлхий зэрэг амьтадтай хамт дүрслэхдээ богинохон биетэй, өргөн том цээжтэй, толгойгоо доош тонгойлгосон, ээтгэр хамартай, хурц махир соёотой, зогсож байгаа болон давхиж байгаа зэргийг тод томруун үзүүлсэн байдаг (Зураг 5). Ингэж дүрслэхдээ дүрслэлийн хоёр өөр арга буюу биеийн гадаад тэгийг нь хөвөөлөн цохих, бүх талбайгаар нь хонхойлон цохих гэсэн хоёр арга ашигласан байдаг. Ийнхүү гахайг эртний нүүдэлчдийн тотем-бугын хамт буган хөшөөнөө олонтоо дүрсэлсэн нь ихээхэн анхаарал татсаар иржээ. Тиймээс ч зарим судлаачид буган хөшөөн дээрх буга болон гахайн дүрсийг онцгой утга агуулгатай хэмээн үздэг төдийгүй Монгол болон түүний хөрш зэргэлдээх нутгуудын эртний урлагт зэрлэг бодон гахайн дүрслэлийн хамгийн эртний хэлбэрүүд төдийгүй түүнийг шүтэн бишрэхтэй холбоотой ёс заншлын нарийн хэлбэршсэн уламжлал өнөө хүртэл хадгалагдан үлдсэн байна.

Амьтны загварт урлагийн эхэн үед гахайг зөвхөн хадны зураг, буган хөшөөнд дүрсэлж, хүрэл зэр зэвсэгт урлаж байсан бол түрүү төмрийн үе болоход илүү олон төрлийн зүйлс дээр урлаж, гол дүрийн амьтдын нэг болгосон юм. Хөгжингүй ба хожуу хүрлийн үед холбогдуулан үзэж болох гахайн дүрс бүхий толттой бөгтөр мөртэй хутга болон чичлүүр хутга Монгол болон Умард Хятадаас хэд хэд олдсон (Зураг 13. 17, 15. 13).

Мийгийн овгийн амьтад. Эрэн цоохор биетэй мийгийн овгийн амьтад дүрсэлсэн буган хөшөө Монголоос 30 олдсон байна (Зураг 5). Тэдгээр мийгийн овгийн амьтдыг амаа ангайсан, хурц араа шүдтэй, биеэ хураасан, цагаригласан болон харайж буйгаар, хөлийн сарвуу, хумс, урт сүүл, жижиг чих, богино хоншоор зэрэг онцлог зүйлсийг зориудаар

тодотгон сийлэхдээ тогтсон нэг орон зайд бус харин бусад амьтдын завсар зайд жижиг хэмжээтэйгээр нэг бол босоо, эсвэл цагариглан хэвтсэн байдалтайгаар дүрсэлжээ. Ингэж дүрслэхдээ тэдний биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохиж, тагнай хээгээр бар, мануул мэт эрээн зүстэй, зууван дугуй хонхороор ирвэс мэт эрээн цоохор биетэй, эсвэл биеийг бүх талбайгаар нь хонхойлон цохиж урласан байна.

Төв Азийн түрүү үеийн нүүдэлчдийн дунд муур шүтэх үзэл хомс бөгөөд харин мийгийн овгийн амьтад болох барс, ирвэс, шилүүсийг хүндэтгэн үзэх үзэл бий болсныг хүрлийн үеийн археологийн олдворуудаас харж болно. Буган хөшөөнд дүрсэлсэн мийгийн овгийн эдгээр амьтдын язгуур үзэл санаа чухам юу болохыг тодорхойлох баримт хэрэглэгдэхүүн ховор хэдий ч түүнийг хамгаалах бэлгэдэлтэй холбоотой хэмээн үздэг.

Нүүдэлчид хүч чадлын бэлэгдэл болгон мийгийн овгийн амьтдыг хувцас, бүсний чимэглэл, толь болон зэр зэвсэг дээр урласан байдаг. Тэдгээрийг хадны зураг болон буган хөшөөнд дүрсэлдэгтэй ижил төстэй дүрслэн үзүүлсэн байх бөгөөд ийм эд өлгийн зүйлс Монгол, Ордос, Умард Хятадаас хэдэн арваараа илэрч олдсон байна (Зураг 12). Мийгийн овгийн амьтдын дүр түрүү төмрийн үед илүү олон төрлийн эд зүйлс дээр илүү загварчилсан байдлаар урлагдах болжээ.

Шувуу. Энэ үеийн хадны зураг, буган хөшөө болон эд зүйлс дээр шувуу дүрсэлж, урласан тохиолдол нэлээд бий бөгөөд хадны зураг болон эд зүйлс дээр урласан нь тооны хувьд хамгийн олон нь юм. Шувууг гоёл чимэглэл, ахуйн хэрэглээ болон зэр зэвсгийн зүйлс дээр урласан байна. Хутганы толт, балтаг, шөвөгний толгой дээр ихэвчлэн махир бүдүүн хошуутай махчин шувуу, гоёл чимэглэлийн зүйлс дэр далавчаа дэлгэн нисч буй, эсвэл цомцойн суусан шувууд дүрсэлсэн байдаг (Зураг 11).

Гөрөөс. Энэ үеийн эд өлгийн зүйлс дотор гөрөөсийн дүр тун ховор тохиолддог ба харин хожмын төмрийн түрүү үеийн олон төрлийн эд зүйлст түгээмэл дүрслэгдсэн байдаг. Хожуу хүрлийн үед холбогдуулан үзэж болох нэг чичлүүр хутга Умард Хятадаас олдсон ба уг чичлүүр хутганы толт дээр дээрээс доош цуварсан бүлтгэр том нүдтэй, дэлдгэр чихтэй 3 гөрөөсний толгой урлажээ (Зураг 15. 16).

Товч дүгнэлт

Монголын тал нутгийн нүүдэлчдийн урлаг суурьшмал соёл иргэншлийн урлагаас ур хийц, утга агуулга, бэлгэдэл зэргээрээ эрс ялгаатай болох нь тод харагдаж байна. Нүүдэлчдийн урлаг бол тэдний амьдрах орчин, эрхлэх аж ахуй, өдөр тутмын амьдралын хэв маяг, ертөнцийг үзэх үзэл зэргээс урган гарч, бүтээлч сэтгэлгээгээр нь улам баяжин хөгжиж

Евразийн өргөн уудам тал нутагт түгэн дэлгэрчээ.

Нүүдэлчдийн орон зайн урлаг (хадны зураг, буган хөшөө, чимэглэх урлаг) -ийн дурсгалуудын гол дүрүүдийг зэрлэг ан амьтад эзэлж байгаа бөгөөд тэдгээр нь тухайн орон нутгийн уугуул амьтад тул тэдний аж төрөх ёс, ертөнцийг үзэх үзэлтэй салшгүй холбоотой юм.

Ийнхүү хөгжингүй ба хожуу хүрлийн үеийн урлагийн гол дүрүүд хожмын Аржан, Пазырык, Чандмань-Сагил, Дөрвөлжин булш, Тагарын соёлын урлагийн үндсэн дүрүүд болсон төдийгүй илэрхийлэх утга агуулгын хувьд гүн гүнзгий болж улам цааш төгс төгөлдөр болон хөгжсөн байна. Өөрөөр хэлбэл, “Амьтны загварт урлаг” анх НТӨ XIII зуунд Төв Азид буюу одоогийн Монголын нутаг дэвсгэрт үүсэн хөгжиж, төмрийн түрүү үе буюу НТӨ VII-III зуун гэхэд нийт Евразийн өргөн уудам тал нутагт түгэн дэлгэрч, урлагийн оргил үедээ хүрсэн байна.

Мөн түүнчлэн Хиргисүүр–Буган хөшөөний соёлын гол элемент болох зэр зэвсгийн зарим төрөл, амьтны загварт урлагийн хэв маяг, сүрлэг том оршуулгын байгууламж хийх санаа сэдэл зэрэг нь Төв Азид скифийн хэмээх түүхэн шинэ эрин үеийн соёл бүрэлдэн тогтоход шууд нөлөөлсөн байна.

Abstract

The key characters of animal-style art in the Middle and Late Bronze Age

Jamiyan-Ombo Gantulga

This paper aims to illuminate the archaeological cultures of the Middle and Late Bronze Ages in the neighboring regions of Mongolia. It delves into the phases and chronology of Mongolia's Bronze Age development, scrutinizing key characters and their symbols in early animal-style art. The artistic expressions stemming from the nomadic way of life are categorized as “animal-style art,” wherein nomads transitioned the characters from two-dimensional to three-dimensional representations a significant and invaluable contribution to the history of global art. The distinctive characters of art from the Middle and Late Bronze Age not only played a central role in subsequent cultures such as Arjan, Pazyryk, Chandman-Sagil, Slab Burial, and Tagar but also evolved in terms of expressive meaning, attaining a heightened level of perfection. In other words, the origins of this distinctive “animal-style art” can be traced back to the 13th century BC in Central Asia, particularly within the territory of present-day Mongolia. Subsequently, it proliferated across the expansive plains of Eurasia, reaching its artistic zenith between the 7th and 3rd centuries BC.

Keywords: Animal-style art, key characters, Middle and Late Bronze Age, archaeological cultures, Siberia, Northern China, Mongolia

Ном зүй

Бадамхатан, С. (1965). Хөвсгөлийн Дархад ястан. – ШУАХ. – УБ. – 257 т.

Батсүх, Д., Энхбаяр, Г. (2021). Булган аймгийн буган хөшөөд. – Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. – Боть I, – УБ., 2018: 342-389.

Волков, В.В. (1967). Бронзовый и ранний железный век северной Монголии. – *Studia Archaeologica*, T. V, Fasc. I. – УБ. 1967. – 147 с.

Гантулга, Ж. (2021). Ан амьтдын дүрслэл. – Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. Ред. Ц. Төрбат. – Боть III, – УБ., 2021: 134-150.

Гантулга, Ж., Идэрхангай, Т. (2021). Архангай аймгийн буган хөшөөд. – Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. Ред. Ц. Төрбат. – Боть I, – УБ., 2021: 24-193.

Гантулга, Ж., Ерөөл-Эрдэнэ, Ч., Магай, Ж. (2018). Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн судалгаа. – Хойд Тамирын хөндий дэх археологийн судалгаа – II. – УБ. – 191 т.

Гришин, Ю.С. (1981). Памятники неолита, бронзового и раннего железного веков лесостепного Забайкалья. – Москва. – 202 с.

Грязнов, М.П. (1958). Древнее искусство Алтая. – Ленинград.

Дундговь ... (2011). Дундговь аймгийн музейн хүрэл цуглуулга. – УБ. – 158 т.

Кочевники ... (2012). Кочевники Евразии на пути к империи. Каталог выставки. – Санкт-Петербург. – 271 с.

Кубарев, В.Д. (1991). Курганы Юстыда. – Новосибирск. – 188 с.

Кубарев, В.Д., Цэвээндорж, Д., Якобсон, Э. (2005). Петроглифы Цагаан Салаа и Бага Ойгура (Монгольский Алтай). – Новосибирск: Изд-во Института археологии и этнографии СО РАН, 2005. – 640 с.

Лазаретов, И.П., Поляков, А.В. (2008). Хронология и периодизация комплексов эпохи поздней бронзы Южной Сибири. – Этнокультурные процессы в Верхнем Приобье и сопредельных регионах в конце эпохи бронзы. – Барнаул. 33-55.

Новгородова, Э.А. (1962). Ножи карасукского времени из Монголии и Южной Сибири. – Монгольский археологический сборник. – Москва.

Новгородова, Э.А. (1970). Центральная Азия и Карасукская проблема. – Москва. – 189 с.

Новгородова, Э.А. (1989). Древняя Монголия. –

Москва. – 383 с.

Парцингер, Г. (2000). Сейминско – Турбинский феномен и формирование Сибирского звериного стиля. – Археология, Этнография и Антропология Евразии. 1. – Новосибирск, 66-75.

Пүрэв, О. (2009) Монгол бөөгийн шашин. – УБ.

Төрбат, Ц., Эрдэнэболд, Л. (2020). Дөрвөлжин булшны тархац, түүний эздийн оршуулгын ёс, онцлог. – Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил. – УБ., 2020: 87-117.

Цэвээндорж, Д. (1999). Монголын эртний урлагийн түүх. – УБ. – 316 с.

Цэвээндорж, Д. (2003). Монголын археологи, урлагийн ховор шинэ олдворууд. – *Studia Archaeologica*, T. XXI, Fasc. 4. – УБ., 2003: 52-58.

Членова, Н.Л. (1972). Хронология памятников Карасукской эпохи. – Москва. – 247 с.

Членова, Н.Л. (1976). Карасукские кинжалы. – Москва. – 116 с.

Эрдэнэ-Очир, Н., Худяков, Ю.С. (2016). Монголын эртний нүүдэлчдийн зэр зэвсэг (НТӨ II мянган жил – НТӨ III зуун). – УБ. – 195 р.

Энхтүвшин, Б., Санжмятав, Т. (2006). Нүүдэлчдийн соёл иргэншил ба Монголын хүрэл зэвсгийн үеийн дурсгал. – УБ. – 180 т.

Эрдэнэчулуун, П. (2011). Тэнгэрийн илд. П.Эрдэнэчулууны цуглуулга. – УБ. – 495.

The Ancient culture ... (2008). The Ancient Culture of Mongolia. – Seoul. pp. 166.

Badma-Oyu, B. (2018). Animal Spine in Early Nomad's Art. – *Sayan-Altai Scientific Review*, 2018, No. 1 (21): 31-34.

Bunker, E.C., Chatwin, C.B., Farkas, A.R. (1970). Animal Style Art from East to West. – New York. – 186 p.

Bunker, E.C., Kawami, T.S., Linduff, K.M., En, W. (1997). Ancient Bronzes of the Eastern Eurasian steppes from the Arthur M. Sackler collections. – Japan. – 401 p.

Bunker, E.C. (2002). Nomadic art of the eastern Eurasian steppes: The Eugene V. Thaw and other New York collections I Emma C. Bunker; with contributions by James C.Y. Watt, Zhixin Sun. – New York.

Jacobson, E., Kubarev, V.D., Tseveendorj, D. (2001). Mongolie du Nord-Ouest: Tsagaan Salaa / Baga Oigor. Repertoire des petroglyphs d'Asie Centrale (ed. J.A.Sher and H.-P.Francfort). Tom.V. 6. – Paris: De Boccard. – 132 p. 346 tab. 399 photos.

Jaeger, U., Kansteiner, S. (2011). Ancient Metalwork from the Black Sea to China in the Borowski collection. – Druckhaus Koethen, Germany. – 186 p.

Hearn, M.K. (1987). Ancient Chinese Art. The Ernest Erickson collection in the Metropolitan Museum of Art. – New York.

Loehr, M. (1953). The Bronze Styles of the Anyang Period (1300-1028 B.C.). Archives of the Chinese Art

Society of America, 7, 42-53. Retrieved March 13, 2020, from www.jstor.org/stable/20066953.

Loehr, M. (1956). Chinese Bronze Age Weapons. – Michigan: The University of Michigan Press, Ann Arbor. – 233 p.

Ordos ... (2006). Ordos Bronze Wares. – Hohhot. – 345 p.

Rawson, J., Bunker, E.C. (1990). Ancient Chinese and Ordos Bronzes. – London. – 362 p.

Salmony, A. (1933). Sino-Siberian Art in the collection of C.T. Loo. – Paris. Pl. XLIV. – 164 p.


Salmony, A. (1998). Sino-Siberian Art in the collection of C.T. Loo. Edited by Bruce L. Miller. – Thailand.

So, J.F., Bunker, E.C. (1995). Traders and Raiders on China's Northern Frontier. – Seattle and London. – 195 p.


Treasures ... (1998). Treasures of the Eurasian steppes. Animal art from 800 BC to 200 AD. – New York. – 176 p.

Wagner, M., Butz, H. (2007). Nomadenkunst. – Archaeologie in Eurasien, Band 23. – Mainz. – 101 p.

Received: Feb 16, 2024; Revised: March 20, 2024; Accepted: March 30, 2024



Зураг 1. Монгол ба түүний хөрш зэргэлдээ бүс нутаг дахь хөгжингүй хүрлийн үеийн археологийн соёлууд



Зураг 2. Монгол ба түүний хөрш зэргэлдээ бүс нутаг дахь хожуу хүрлийн үеийн археологийн соёлууд


Хөгжингүй ба хожуу хүрлийн үеийн урлагийн гол дүрүүд ¹
(Монгол, Өмнөд Сибир, Умард Хятад, Казахстан)

Хоёр нутагтан	Домгийн амьтад	Жигүүртэн	Араатан амьтад	Өвсөн тэжээлт амьтад	Хүн	
						Алт
						Хүрэл
						Чулуу (хат, гантиг)
						Яс
						Шавар

¹ Энэхүү хүснэгтэнд эдгээр бүс нутгаас олдсон бүх олдворыг оруулах боломжгүй тул зөвхөн төлөөлөл болох олдворуудыг оруулсан болно.

Монголын хүрлийн үеийн он цагийн үечлэл


Түүхэн үе		Он цаг (НТӨ)	Баруун Монгол	Төв Монгол	Дорнод Монгол
Түрүү төмөр	Түрүү	300	Пазырыкийн соёл, Чандмань-Сагилын соёл	Дөрвөлжин булшны соёл	
		400			
		500			
		600			
		700			
Хүрэл	Хожуу	800	Хиргисүүр-Буган хөшөө Баянтүмбэ / Баян-Өндөр Сагсай хэлбэрийн булш		
		900			
		1000			
		1100			
		1200			
		1300			
		1400			
		1500			
	Хөгжингүй	1600	Түрүүлгэ нь харуулсан оршуулгат булш		Неолитын бууц, суурин
		1700	Мөнххайрханы соёл		
		1800			
		1900			
		2000			
	2100				
	Түрүү	2200	Хэмцэгийн соёл, Цэнгэл хэлбэрийн байгууламж		
		2300			
		2400			
		2500			
		2600			
2700					
Энеолит		2800	Афанасевын соёл		
		2900			
		3000			
		3100			
		3200			
		3300			




Зураг 3. Буган хөшөө, түүний дүр, дүрслэл (© J. Magail)

Profession	Count
Мэдлхий	1
Загас	2
Шувуу	3
Нохой	1
Чоно	3
Мийгийн овгийн амьтад	30
Үхэр	1
Гахай	12
Янгир	32
Адуу	73
Хандгай	2
Согоо	18
Буга	24
Загварчилсан буга	592

21



Зураг 6. а. Монголын төвийн бүс нутгийн хүрэл, түрүү төмрийн үеийн хадны зургийн ерөнхий дүр, дүрслэлүүд



б. Монгол Алтайн хүрэл, түрүү төмрийн үеийн хадны зургийн дүрүүд
(Кубарев, Цэвээндорж, Якобсон 2005: 121, рис. 16)



Зураг 7. Шүтлэг бишрэлийн холбогдолтой зүйлс (Монгол ба Умард Хятад):

1-4. Хүний дүрст хүрэл онго, Монгол (1 – *The Ancient culture ...* 2008: 84; 2-4 – Энхтүвшин, Санжмятав 2006: 142-143, зур. 2-4); 5-8. Хүний нүүрний дүрст хүрэл онго, Умард Хятад (5, 6 – Wagner, Butz 2007: 85, Kat. Nr. 64 a-b; 7 – Jaeger, Kansteiner 2011: 60, no. 76; 8 – Salmony 1933: Pl. XVI. 2), 9-11. Хүрэл халбага, Умард Хятад (9 – Salmony 1998: 112, no. 158; 10 – Bunker 2002: 192, no. 183; 11 – Bunker 1997: 128, no.13)



Зураг 8. Янгирын дүрст хүрэл эдлэлүүд:

1. Бүсний чимэглэл, Дундговь ОНСМ; 2. Товруу, Булган, Өмнөговь; 3, 4. Янгирын дүрст эдлэлийн хугархай, Монголын Үндэсний Музей, Дундговь; 5. Товч, Ордос; 6. Давхиж буй янгир, Мандах, Дорноговь; 7-9. Хөгжмийн чавхдас тохируулах хэрэгсэл (?), Архангай, Дорноговь, Монгол, Умард Хятад (1 – Дундговь ... 2011: 111, зур. 8; 2, 4, 6 – Эрдэнэчулуун 2011: 103, 106, 137, дүг. 75, 78, 128; 5 – Wagner, Butz 2007: 23, no. 17; 7 – Цэвээндорж 2003: 52-58, Зур. 1; 8 – Тэнгэрийн илд 2011: 134, дүг. 124; 9 – Hearn 1987: 47, no. 36;)



Зураг 9. Аргалийн толгойн дүрст алтан болон хүрэл эдлэлүүд:

1. Тэвш уул, Богд сум, Өвөрхангай; 2. Баруун Монгол; 3. Ордос, Өвөр Монгол; 4. Өмнөд Сибир (1 – Бадма-Оюу 2018: 31-34, fig. 1; 2 – Treasures ... 1998: 127, no. 137; 3 – Ordos ... 2006: 118; 4 – Salmony 1933: 78, Pl. XXXII. 9)



Зураг 10. Адууны дүрст эдлэлүүд:

1. Хутганы толтны чимэглэл, Нарийнтээл, Өвөрхангай; 2, 7. Модон гадас (таяг) -ны үзүүрийн чимэглэл, Умард Хятад; 3. Хүрэл морь, Ихтамир, Архангай; 4. Бүсний чимэглэл, Умард Хятад; 5. Хүрэл дэгээ, Онтарио музей, Торонто; 6. Тэрэгний чимэглэл, Умард Хятад; 8. Нум сумтай анчин, морин тэрэг, бугын дүрслэл бүхий ясан сийлбэр, 102-р булш, Наншанген, Өвөр Монгол; 9. Морин тэрэгний дүрст чимэглэл, Умард Хятад; 10. Адуу, янгир, үхэр, тэмээ дүрс бүхий хүрэл толь, Волга гол, (1 – Эрдэнэчулуун 2011: 80, дүг. 47; 2 – Bunker, Chatwin, Farkas 1970: 89, no. 57; 3 – Гантулга нар 2023; 4 – Wagner, Butz 2007: 6, no. 3; 5 – So, Bunker 1995: 36, Fig. 9; 6 – Bunker, Chatwin, Farkas 1970: 85, no. 53; 7 – Bunker et al. 1997: 130, no. 17; 8, 9, 10 – Bunker 2002: 16, 57, 179, Fig. 17, no. 23, 167)



Зураг 11. Шувууны дүрст хүрэл эдлэлүүд:

1. Бүсний чимэглэл, Даланзадгад, Өмнөговь; 2. Товч, Ордос; 3. Хувцасны чимэглэл, Умард Хятад; 4. Хүрэл шөвөг, Монгол; 5. Модон гадас (таяг) -ны үзүүрийн чимэглэл, Умард Хятад (1 – Эрдэнэчулуун 2011: 252, дүг. 261; 2 – Wagner, Butz 2007: 83, no. 62; 3 – Bunker 2002: 156, no. 133; 4 – The Ancient culture ... 2008: 76; 5 – Bunker, Chatwin, Farkas 1970: 89, no. 58)



Зураг 12. Мийгийн овгийн амьтдын дүрст хүрэл эдлэлүүд:
 1-7. Бүсний чимэглэл, Монгол, Умард Хятад; 8, 9. Хүрэл толь, Умард Хятад
 (1, 2, 4 – Эрдэнэчулуун 2011: 233, 223, 205, дуг. 244, 230, 210;
 5, 6, 7, 8, 9 – Wagner, Butz 2007: 46, 42, 44, 57, no. 36, 32, 34, 45, 45.2)



Зураг 13. Монголоос олдсон амьтны дүрст зарим зэр зэвсэг:

1. П.Эрдэнэчулууны цуглуулга; 2. Дүрслэх урлагийн музей; 3. Өмнөговь ОНСМ; 4. Монголын Үндэсний музей; 5. Өмнөговь ОНСМ; 6. Сүхбаатар аймаг; 7. Газрын нэр тодорхойгүй; 8. Баянхонгор аймаг; 9. Өмнөговь ОНСМ; 10. Ханхонгор, Өмнөговь; 11. Дарви сум, Ховд; 12. Дүрслэх урлагийн музей; 13. Баянхонгор аймаг; 14. Улаанбаатар; 15. Газрын нэр тодорхойгүй; 16. Дундговь ОНСМ; 17. Дундговь аймаг; 18. Өвөр Монгол; 19. Сайнцагаан, Дундговь; 20. Сүхбаатар аймаг; 21. Дорноговь ОНСМ; 22. Монгол цэргийн музей; 23, 24. Ховд ОНСМ; 25. Бөмбөгөр, Баянхонгор; 26. Говь-Алтай ОНСМ; 27. Баяндэлгэр, Сүхбаатар; 28. Говь-Алтай аймаг; 29, 30. Монголын Үндэсний музей
(1, 6, 8, 10, 17, 18, 19, 25, 27, 28 – Эрдэнэчулуун 2011: 266-269, 292-293, 286-289, 336, 296, 299-300, 301, 297-298, дүг. 282, 294, 292, 341, 297, 300, 301, 302, 298, 299; 3, 13, 14, 20, 29, 30 – Энхтүвшин, Санжмятав 2006: 89, 93, 80, 95, зур. 20, 24, 25, 16, 33, 32; 5 – Волков 1967: рис. 2. 11; 7, 15 – The Ancient culture ... 2008: 51, 56; 9 – Волков 1967: рис. 5.1; 11, 12 – Эрдэнэ-Очир, Худяков 2016: зур. 21. 5, 9; 16 – Дундговь ... 2011: 68, зур. 3)



Зураг 14. Өмнөд Сибирийн бүс нутгаас олдсон хүн, адуу, янгир, аргаль, шувуу болон араатан амьтны дүрст зэр зэвсэг, эд зүйлс:

1. Сейма, 2, 3. Турбино (1-3 – Членова 1972: табл. 69. 1-3); 4. Бийск (4 – Членова 1976: табл. 6.6); 5. Усть-Тулутай; 6. Котокель; 7. Кузьмино (5, 6, 7 – Новгородова 1970: рис. 36. 7-9); 8. 1-р були, Карасук VIII (8 – Лазаретов, Поляков 2008: 45, рис. 6. 27); 9. Канск (9 – Членова 1976: табл. 2. 22); 10. Сабинск (10 – Новгородова 1970: рис. 19. 18); 11, 12. Өмнөд Сибир (11, 12 – Bunker et al. 1997: 151, no. 45, 46); 13. 1-р були, Абакан; 14. Красный Яр; 15. Топаново; 16. Марьясова; 17. Бея; 18. Минусинск; 19. Беллык; 20. Бейск; 21. Минусинск; 22. Большое (13-22 – Членова 1972: табл. 9. 1-10); 23. Петропавловка; 24. Усть-Карск; 25. Усть-Тулутай; (23, 24, 25 – Гришин 1981: 177, рис. 67. 1, 4); 26. Минусинск (26 – Кочевники ... 2012: кат. 59); 27, 28, 29. Өмнөд Сибир (27, 28, 29 – Bunker et al. 1997: 152-153, no. 48, 49, 50); 30. Ладейский були (30 – Членова 1972: табл. 19. 12); 31, 32. Минусинск; 33. Хакск; 34. Ростовка (31, 32, 33, 34 – Членова 1972: табл. 70. 7, 71. 7-9)



Зураг 15. Умард Хятадын нутгаас олдсон хүн, амьтны дүрст зэр зэвсэг, эд зүйлс:

1, 3-7, 11, 12, 21. Янгирын толгой бүхий бөгтөр мөртэй хутга (1 – Bunker et al. 1997: 121, no. 6; 2, 3 – Bunker 2002: 75, no. 41; 4-7 – Saltony 1933: Pl. XXXVI. 1, 2, 4, 5; 11, 12 – Членова 1972: табл. 24. 11, 13; 21 – Bunker et al. 1997: 138, no. 29); 8, 9, 22, 23. Адууны толгой бүхий бөгтөр мөртэй хутга (8 – Saltony 1933: Pl. XXXVI. 3; 9, 22 – Членова 1972: табл. 24. 8-10; 24 – Hearn 1987: 42, no. 26); 10, 22, 25. Аргалийн дүрст бөгтөр мөртэй хутга (10, 21, 24 – Членова 1972: табл. 71. 1, 6, 11); 13-20. Хүн, шувуу, гахай, буга, зээрийн дүрст чичлүүр болон бөгтөр мөртэй хутга (13 – Членова 1972: табл. 26. 1; 14 – So, Bunker 1995: 122, no. 39; 15 – Bunker 2002: 79, no. 45; 16 – Членова 1976: табл. 10. 13; 17, 18 – Членова 1972: табл. 25. 2, 3; 19, 20 – Treasures ... 1998: 72-73, no. 67, 68); 26-28. Хүн, амьтны дүрст илдний хуй, байлдааны зээтүү, сүх (26 – So, Bunker 1995: 48, Pl. 9; 27 – Членова 1972, табл. 26. 3; 28 – Treasures ... 1998: 143, no. 15)